



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 28 (553)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Хот байгуулалтын тухай (Шинэчилсэн найруулга)*
- *Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны долодугаар сарын 29

№28 (553)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

441.	Хот байгуулалтын тухай (Шинэчилсэн найруулга)	814
442.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	823
443.	Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	823
444.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	825
445.	Замын хөдөлгөөны аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	826
446.	Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	826
447.	Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	826
448.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	827
449.	Цагдаагийн байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	827
450.	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	827
451.	Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	830
452.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	830

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

453.	Нэрэмжит болгох тухай	Дугаар 164	830
454.	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тоог ного явуулах тухай	Дугаар 167	830
455.	Зээл олгох тухай	Дугаар 168	831
456.	Журам батлах тухай	Дугаар 170	831
457.	Журам батлах тухай	Дугаар 172	833

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

458.	Орон сууцны болон орон сууц хувьчлах тухай хуулиудын зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 25	835
459.	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 26	837
460.	Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 29	839

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ

(Шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол улсын хот байгуулалтын бодлогын хүрээнд хүн амын нутагшилт, суурьшил болон харьцангуй бие даан хөгжих бүс нутгийн хөгжлийн зохистой бүтэц бүрдүүлэх, хот, тосгоныг хот төлөвлөлтийн дагуу барьж байгуулахад төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хот байгуулалтын тухай хууль тогтоомж

2.1. Хот байгуулалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "хот байгуулалт" гэж түүх, соёл иргэншлийн уламжлал, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхийн тулд бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах, барьж байгуулах, иж бүрэн тохижуулах цогцолбор үйл ажиллагааг;

3.1.2. "хот төлөвлөлт" гэж тухайн хот, тосгоны ирээдүйн хөгжил, эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн зөв зохистой үйлчилгээг бий болгохын тулд газар ашиглалт, хотын барилгажилт болон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн үе шат бүхий төлөвлөлтийн мэргэжлийн үйл ажиллагааг;

3.1.3. "хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" гэж хот, тосгоны хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн хот байгуулалтын үндсэн баримт бичгийг;

3.1.4. "хот байгуулалтын баримт бичиг" гэж нутаг дэвсгэр, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг, түүний суурь судалгааг;

3.1.5. "бүсчлэл" гэж хот, тосгоныг хөгжүүлэх төлөвлөлтийн үе шатанд нутаг дэвсгэрийг ашиглалтын үүрэг, зориулалтаар бүсчлэн хувааж, ашиглалтын төрлийн хязгаарлалт тогтоохыг;

3.1.6. "хот байгуулалтын норм ба дүрэм, журам" гэж хот байгуулалт, хот төлөвлөлтөд мөрдөх нийтлэг шаардлагын хэм хэмжээг тусгасан техникийн норматив баримт бичгийг;

3.1.7. "хот байгуулалтын кадастр" гэж нутаг дэвсгэрийн ашиглалт, хүрээлэн буй орчны төлөв байдал, инженерийн шугам сүлжээний хангамжийн түвшин, барилга байгууламж, хүн амын амьдрах орчны чанарын тухай байр зүйн зураглал, мэдээллийн нэгдмэл санг;

3.1.8. "хот байгуулалтын техникийн нөхцөл" гэж хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, барьж байгуулахад шаардагдах дэд бүтцийн эх үүсвэр, технологийн шийдлийн талаар эрх бүхий хуулийн этгээдээс авах зөвшөөрлийг;

3.1.9. "инженерийн бэлтгэл ажил" гэж хот, тосгоны барилга байгууламж барьж байгуулахад зориулж тухайн газрын гадаргууг тэгшилгээ хийх, үер, хөрсний нуралт, элсний нүүлт цасны хунгарлалтаас хамгаалах бэхлэлт, далан суваг, гүүр, гарц, зам, талбай барьж байгуулах урьдчилсан арга хэмжээг;

3.1.10. "инженерийн дэд бүтэц" гэж эрчим хүч, цэвэр, бохир усны болон зам, замын байгууламж, тээвэр, харилцаа холбооны шугам сүлжээ, барилга байгууламжийг;

3.1.11. "нийгмийн дэд бүтэц" гэж соёл, боловсрол, худалдаа, ахуйн үйлчилгээний барилга байгууламжийн цогцолборыг;

¹ Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

3.1.12. "хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө" гэж хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн дүүрэг, орон сууцны болон гэр хорооллын газар зохион байгуулалт, барилгажилт, тохижилтын төлөвлөлт, инженерийн шугам сүлжээний хангамжийг нарийвчлан тодотгож төлөвлөсөн хот байгуулалтын үйл ажиллагааны баримт бичгийг;

3.1.13. "хот төлөвлөлтийг хэрэгжүүлэгч" гэж энэ хууль болон бусад хуульд заасны дагуу төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, тэдгээрээс эрх авсан мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийг;

3.1.14. "шинэ хороолол, бичил хороолол" гэж эрх бүхий байгууллагын баталсан хот байгуулалтын баримт бичигт төлөвлөгдсөн, зориулалтын бүсчлэлийн дагуу хотын нутаг дэвсгэрт шинээр бий болох суурьшлыг;

3.1.15. "гэр хорооллын төлөвлөлт" гэж бие даасан болон төвлөрсөн инженерийн дэд бүтцээр хангагдсан суурьшлын төлөвлөлтийг;

3.1.16. "хот төлөвлөлтийн суурь судалгаа" гэж хот төлөвлөлтийг хэрэгжүүлэгч этгээд хот төлөвлөлтийг хэрэгжүүлэхийн тулд газар чутаг, хүн ам, эдийн засаг, нийгэм, соёл, зам тээвэр, байгаль орчин, газар ашиглалт болон бусад зүйлийн талаар хийсэн судалгааг;

3.1.17. "онцгой зохицуулалттай объект" гэж батлан хамгаалахын болон бусад стратегийн зориулалттай объектыг.

4 дүгээр зүйл. Хот байгуулалт, төлөвлөлтийн үндсэн зарчим

4.1. Хот байгуулалт, төлөвлөлтөд дараах үндсэн зарчим баримтална:

4.1.1. Монгол Улсыг хөгжүүлэх үндэсний хөгжлийн стратегийг хангах;

4.1.2. хүний аюулгүй байдал, байгаль экологи, эдийн засаг, нийгмийн хөгжлийн гэнцвэрт байдлыг хангах;

4.1.3. хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч этгээдийн эрх ашгийг тэгш хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хот байгуулалтын үйл ажиллагааны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

5 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

5.1. Улсын Их Хурал хот байгуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. хот байгуулалтын талаархи төрийн бодлогыг тодорхойлох;

5.1.2. хотыг шинээр байгуулах болон татан буулгах, нүүлгэн шилжүүлэх тухай шийдвэр гаргах;

5.1.3. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах;

5.1.4. чөлөөт бүсийн хөгжлийн төсөл болон түүний хилийн цэсийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах;

5.1.5. нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах.

6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

6.1. Засгийн газар хот байгуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. бүсийн хөгжлийн төсөл батлах;

6.1.2. Улсын Их Хурлаас тодорхойлсон хот байгуулалт, төлөвлөлтийн төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

6.1.3. хот байгуулалтын төрийн бодлогын хүрээнд улс, бүс нутаг, хот, тосгоны тогтвортой хөгжлийг хангах, салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах;

6.1.4. бүсийн хөгжлийн тулгуур төв хот, түүнчлэн томоохон уул уурхайн орд газар, үйлдвэр, нисэх онгоцны буудлыг даган бий болсон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах;

6.1.5. нийслэл болон бүсийн хөгжлийн тулгуур төв хотыг хөгжүүлэх арга хэмжээний дөрвөн жилийн төлөвлөгөөг батлах;

6.1.6. аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, онцгой зохицуулалттай объектын ерөнхий төлөвлөгөөг батлах.

7 дугаар зүйл. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

7.1. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хот байгуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. хот байгуулалтын төрийн бодлогыг хэрэгжүүлж, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.2. аймаг, нийслэлийн Хот байгуулалт, барилга захиалагчийн албаны үлгэрчилсэн дүрмийг баталж, мөрдүүлэх;

7.1.3. хот байгуулалтын норм ба дүрэм, журам батлах;

7.1.4. аж ахуйн нэгж, байгууллагад хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх олгох;

7.1.5. хот байгуулалтын баримт бичигт улсын экспертизийн дүгнэлт гаргах;

7.1.6. хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулахтай холбогдсон журам баталж, мөрдүүлэх;

7.1.7. хот байгуулалтын салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулах;

7.1.8. нийслэл болон бүсийн хөгжлийн тулгуур төв хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл боловсруулах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж, зохицуулах;

7.1.9. орон нутгийн зэрэглэлтэй хотын хот байгуулалтын баримт бичгийг боловсруулж батлахад мэргэжлийн удирдлагаар хангаж, хэрэгжилтэнд хяналт тавих;

7.1.10. онцгой зохицуулалттай объект болон түүний нутаг дэвсгэрт хот байгуулалтын үйл ажиллагааны зохицуулалтын журам тогтоох;

7.1.11. барилгажилт, нутаг дэвсгэрийн бүсчлэлийн ашиглалтын хязгаарлалтыг тогтоох;

7.1.12. шинэ хороолол, бичиг хорооллын зураг төсөл, техникийн баримт бичиг болон гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагын боловсруулсан хот байгуулалтын баримт бичгийг батлах.

8 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

8.1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хот байгуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хот, тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлах;

8.1.2. хот байгуулалтын баримт бичигт тусгагдсан төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэх;

8.1.3. хот байгуулалтын баримт бичигт тусгагдсан төсөл, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай гэж үзвэл энэ талаархи Засаг даргын тайланг хэлэлцэх;

8.1.4. хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, барилга байгууламжийн газар олголт, техникийн нөхцлийн үндэслэл, бүрдэл, гүйцэтгэлд хяналт тавих;

8.1.5. бүс нутгийн хөгжлийн төслийн үндсэн шийдэлтэй уялдуулан орон нутгийн зэрэглэлтэй хот болон тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах;

8.1.6. нийслэл, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

8.1.7. шинэ хороолол, хотхон, гэр хороолол, хотын хуучин хэсгийг шинэчлэн барилгажуулах шийдвэр гаргах.

9 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

9.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь хот байгуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. хот, тосгоны батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон барилгажилтын төслийг үндэслэн газар олгох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

9.1.2.аймаг, нийслэлийн ерөнхий архитектурыг 4 жилийн хугацаагаар томилж;

9.1.3.ерөнхий архитектороор удирдуулсан Хот байгуулалт, барилга захиалагчийн албыг байгуулах;

9.1.4.аймаг, нийслэлийн хөгжлийн төсөл, хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, тодотгол, шинэчлэл хийх асуудлыг санаачлан зохион байгуулах;

9.1.5.хот байгуулалтын үйл ажиллагаа болон газар ашиглалт, хамгаалалтад хяналт тавих;

9.1.6.хот байгуулалтын чиглэлээр хийгдсэн ажлын талаархи тайланг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жилд нэг удаа ирүүлэх.

10 дугаар зүйл. Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитектурын эрх, үүрэг

10.1.Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитектор нь хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дүрмийн дагуу дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1.хот байгуулалтын салбарын норматив, эрх зүйн бусад актын төсөл болон тэдгээрийг боловсруулах, өөрчлөх тухай санал оруулах;

10.1.2.орон нутаг дахь хот байгуулалтын бодлого боловсруулахад санал гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

10.1.3.зураг төсөл, хайгуул, шинжилгээний ажлыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;

10.1.4.хот суурины нутаг дэвсгэрт хот байгуулалтын кадастр хөтлөх, хот байгуулалтын архивын санг бүрдүүлэх;

10.1.5.орон нутгийн хот байгуулалтын үйл ажиллагааг зохицуулж, Хот байгуулалт, барилга захиалагчийн албыг өдөр тутмын мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

10.1.6.барилга байгууламжийг барьж байгуулахаас өмнө тухайн газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гудамжны нэр, барилгын дугаарыг тогтоож, газрын кадастрын бүртгэлд оруулах ажлыг зохион байгуулах;

10.1.7.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх;

10.1.8.инженерийн бэлтгэл ажилд хяналт тавих.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хот байгуулалтын баримт бичиг, түүнд тавигдах үндсэн шаардлага

11 дүгээр зүйл. Хот байгуулалтын баримт бичиг

11.1.Хот байгуулалтын баримт бичиг нь дараахь зүйлээс бүрдэнэ:

11.1.1.хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл;

11.1.2.бүс нутгийн хөгжлийн төсөл;

11.1.3.чөлөөт бүс, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө;

11.1.4.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;

11.1.5.хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө;

11.1.6.хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;

11.1.7.барилга байгууламжийн зураг төсөл;

11.1.8.хот төлөвлөлтийн суурь судалгаа.

11.2.Хот байгуулалтын баримт бичгийг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан, сонгон шалгаруулалтаар шалгарсан аж ахуйн нэгж, байгууллага боловсруулна.

11.3.Хот байгуулалтын баримт бичгийг Иргэний хууль²-д заасан ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр боловсруулна.

11.4.Хот байгуулалтын баримт бичгийг боловсруулахад хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан норм ба дүрэм, журмыг мөрдөж, барилга

² Иргэний хууль-Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

байгууламжид тавигдах шаардлага, тэдгээрийн дэд бүтцийн хангамж, ногоон байгууламж, эрүүл ахуй, экологи, галын аюулгүй байдлыг тусгана.

11.5 Дор дурдсан этгээд хот байгуулалтын баримт бичгийн захиалагч байна.

11.5.1.хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүс нутгийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын захиалагч нь хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.

11.5.2.аймаг, нийслэл, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын захиалагч нь тухайн шатны Засаг дарга, хот, тосгоны захирагч.

11.6.Хот байгуулалтын баримт бичгийн захиалагч нь хот байгуулалтын баримт бичигт холбогдох хууль тогтоомж, норм ба дүрэм, журамд заасны дагуу улсын экспертизийн дүгнэлт гаргуулна.

12 дугаар зүйл. Хот байгуулалтын баримт бичигт тавигдах шаардлага

12.1.Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөхцөл, ноёд, экологийн тэнцвэрт байдал, хот байгуулалтын сөрөг үр дагаварт иж бүрэн үнэлгээ өгсний үндсэн дээр хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн үндсэн сүлжээний үйлчлэлийн зохистой хүрээнд тулгуурласан бүс нутгийн оновчтой бүтэц, хот, тосгоны тогтолцоог бүрдүүлэх шаардлагыг хангасан байна.

12.2.Бүс нутгийн хөгжлийн төсөл нь тухайн нутаг дэвсгэрт хот байгуулалтын тодотгосон үнэлгээ хийсний үндсэн дээр бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, бүсийн хөгжлийн тулгуур төв болон нийгэм, соёл ахуйн үйлчилгээний зохистой хүрээгээр бүлэг суурингийн төвийг тогтоон бусад бүс нутагтай харилцан уялдаатай харьцангуй бие дэж хөгжих шаардлагыг хангасан байна.

12.3.Чөлөөт бүс, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө нь хот байгуулалтад тавигдах үндсэн шаардлагыг бүрэн хангасан худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал эрхлэх, дэд бүтцийн хангамж нөхцлийг тооцож төлөвлөсөн байна.

12.4.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь дараахь шаардлагыг хангасан байна.

12.4.1.хүн амын амьдрах, ажиллах таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн, хот, тосгоны хөгжлийн чиглэлийг тодорхойлсон, хот, тосгоны хил хязгаар, газар нутгийн үүргийн бүсчлэл, инженер, зам тээвэр болон нийгмийн дэд бүтцийн хөгжил, түүх, соёлын дурсгалт байгууламж, архитектуры-хот байгуулалтын шаардлага, экологийн болон эрүүл ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байх.

12.4.2.тухайн нутаг дэвсгэрийн инженер-геологи болон байгаль экологийн онцлогт тулгуурлан боловсруулсан суурь судалгаанд үндэслэсэн байх.

12.5.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь тухайн хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэсэн дүүрэг, хороолол, бичил хороолол, талбайн өндөржилт, зай хэмжээ, инженерийн шугам сүлжээний шийдэл, ногоон байгууламж, орчны тохижилтын төлөвлөлтийн норм ба дүрмийн шаардлагыг хангасан, иргэдийн оролцоотой төлөвлөгдсөн байна.

12.6.Хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь тухайн хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу боловсруулсан зураг төслийг хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг тооцож, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тодорхойлсон байх бөгөөд холбогдох норм ба дүрэм, журамд заасны дагуу дараахь асуудлыг тооцон төлөвлөнө:

12.6.1.гудамж, замын сүлжээг тээврийн хэрэгсэл, дугуйтай ба явган зорчигчийн хөдөлгөөн, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, орон зайн зохиомж, орчны барилга байгууламжийн байршил, уран барилгатай нь уялдуулан, тасралтгүй өсөн хөгжих хөдөлгөөнтэй нэгдсэн систем байх;

12.6.2.орон сууц, олон нийтийн барилга болон үйлдвэр, үйлдвэрийн туслах барилга байгууламжийн хоорондын гал тусгаарлах зайг тооцох;

12.6.3.төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн 30-аас доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, автомашины зогсоол байх.

12.7.Орон нутгийн зэрэглэлтэй хотын захирагч нь хотын тогтвортой хөгжлийн бодлогын чиглэл, батлагдсан төлөвлөгөөний дагуу хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 4 жил тутамд боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

12.8.Барилга байгууламжийн зураг төсөл нь хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шийдлүүд.

олгогдсон газрын хэмжээ, зориулалттай уялдсан байх бөгөөд барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас илүүгүй байна.

12.9. Хот төлөвлөлтийн суурь судалгаа нь байгаль орчин, эдийн засаг, нийгэм, хот байгуулалтын асуудлыг иж бүрэн хамруулан тусгасан судалгааны ажил байна.

13 дугаар зүйл. Хот, тосгоны нутаг дэвсгэрийн бүсчлэл

13.1. Хот, тосгоны нутаг дэвсгэрт дараахь бүсчлэлийг хот байгуулалтын норм ба дүрэм, журмын дагуу төлөвлөж тогтооно:

13.1.1. орон сууц, олон нийтийн бүс;

13.1.2. үйлдвэрлэлийн бүс;

13.1.3 инженерийн шугам сүлжээ болон зам тээврийн бүс;

13.1.4 ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүс;

13.1.5 хөдөө аж ахуйн бүс;

13.1.6 зуслангийн бүс;

13.1.7. тусгай зориулалтын бүс.

14 дүгээр зүйл. Нутаг дэвсгэрийн бүсчлэлд тавигдах шаардлага

14.1. Орон сууц, олон нийтийн бүсэд эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үндсэн шаардлагыг хангаж, байгалийн гэрэлтүүлгийн холбогдох норм ба дүрэм, журамд заасны дагуу төлөвлөгдсөн орон сууц, сургалт, соёл, үзвэр, шинжлэх ухаан, эмнэлэг, амралт, сувилал, спорт, худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ, тээвэр, холбооны чиглэлийн үйл ажиллагаа явуулах зориулалттай барилга байгууламж төлөвлөх бөгөөд амьдрах, аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж болохуйц бусад барилга байгууламж төлөвлөхийг хориглоно.

14.2. Үйлдвэрлэлийн бүсэд үйлдвэр, нийтийн аж ахуй, агуулахын зориулалттай барилга байгууламж, тэдгээрийн үйл ажиллагааг хангах инженерийн болон зам тээврийн дэд бүтцийн барилга байгууламжийг төлөвлөнө.

14.3. Инженерийн шугам сүлжээний болон зам тээврийн бүсэд төмөр зам, усан болон авто тээвэр, агаарын тээвэр, инженерийн /цэвэр, бохир усны, дулаан, холбоо, цахилгааны гэх мэт/ шугам сүлжээний барилга байгууламжийг төлөвлөнө.

14.4. Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүсэд хот орчмын ой, ойн хамгаалах зурвас, амралт, сувилал, усан сан, цэцэрлэгт хүрээлэн, спортын цогцолбор, наран шарлагын газар зэрэг олон нийтийг хамрах амралт зугаалгын үйл ажиллагааг зохион байгуулахад зориулагдсан орон зайн задгай орчин, түүнчлэн байгалийн дархан цаазат болон онцгой хамгаалалттай газар нутгийг төлөвлөнө.

14.5. Хөдөө аж ахуйн бүсэд газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх газар, хөдөө аж ахуйн чиглэлийн барилга байгууламж байрлах, хадлангийн зориулалтаар ашиглах нутаг дэвсгэрийг төлөвлөнө.

14.6. Зуслангийн бүсэд иргэд зуны улиралд түр хугацаагаар суурин амьдарч болох хотын төвөөс зайдуу орших төвлөрсөн дэд бүтэцгүй суурьшлын газар нутгийг төлөвлөнө.

14.7. Тусгай зориулалтын бүсэд улсын нөөц газраас гадна иргэний хамгаалалт, батлан хамгаалахын зориулалттай, түүнчлэн хатуу хог хаягдлын цэг, шарилын газар, цогцос чандарлах үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийг төлөвлөнө.

15 дугаар зүйл. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын санхүүжилт

15.1. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлыг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

15.1.1. хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүс нутгийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө, нийслэл болон бүсийн хөгжлийн тулгуур төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, шинэ хороолол, бичил хорооллын төлөвлөгөө, тэдгээрийн суурь судалгааг улсын төсвөөс;

15.1.2. аймаг, орон нутгийг хөгжүүлэх төсөл, аймгийн төв, нийслэл хот орчмын бүсийн дагуул хот, орон нутгийн зэрэглэлтэй хот болон тосгоны ерөнхий төлөвлөгөө, тэдгээрийн суурь судалгааг орон нутгийн төсвөөс;

15.2. Энэ хуульд заасан бусад баримт бичиг боловсруулах ажлыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагч байгууллага, иргэдээс санхүүжүүлж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хот төлөвлөлтийн үйл ажиллагааны зохицуулалт

16 дугаар зүйл. Шинэ хороолол, бичил хорооллын төлөвлөлт, байгуулалт

16.1. Шинэ хороолол, бичил хорооллыг төлөвлөх болон байгуулах асуудлыг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр аймаг, нийслэлийн Засаг дарга санаачилна.

16.2. Шинэ хороолол, бичил хороолол байгуулах тухай шийдвэр гарсан даруйд олон нийтэд мэдээлнэ.

16.3. Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хот, тосгоныг хөгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хамтран оролцох үүрэгтэй.

17 дугаар зүйл. Олон нийтийн санал авах

17.1. Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой төлөвлөлтийн зарчмыг тусгаж ажиллана.

17.2. Хот, тосгоны захирагч нь хот төлөвлөлтийг хэрэгжүүлэхдээ иргэд болон холбогдох мэргэжлийн хүмүүсийн оновчтой саналыг авч хот төлөвлөлтөд тусгана.

18 дугаар зүйл. Олон нийтэд мэдээлэх

18.1. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, хотын захирагчийн ажлын алба нь энэ хуулийн хүрээнд гаргасан аливаа шийдвэрийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлнэ.

19 дүгээр зүйл. Хот, тосгоны эдэлбэр газрын ашиглалт, зохицуулалт

19.1. Хот, тосгоны орон зайн болон газрын нөөцөд хот, тосгоны тогтоогдсон хилийн цэс доторхи нутаг дэвсгэр, газрын доор болон дээр байрлах инженерийн шугам сүлжээ, барилга байгууламж багтана.

19.2. Хот, тосгоны эдэлбэр газрыг хот байгуулалтын баримт бичиг болон хот байгуулалтын норм ба дүрэм, журамд тусгагдсаны дагуу барилгажуулж ашиглана.

19.3. Хот, тосгоны эдэлбэр газарт барилга байгууламж барих, ашиглах газар доорхи болон дээрхи орон зайг ашиглах эрх зүйн горим дэглэмийг

хот байгуулалтын норм ба дүрэм, журмаар тодорхойлно.

19.4. Хот, тосгоны хил хязгаарт багтаж байгаа газар доорхи болон дээрхи орон зай нь тухайн нутгийн захиргааны байгууллагын мэдэлд хамаарагдах бөгөөд дараахь орон зайн хэсэг үүнд хамаарахгүй:

19.4.1. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу газар доорхи нөөц баялгийн геологийн судалгаа хийх, олборлох зэрэг үйл ажиллагаа явуулах зориулалтаар байгууллага, иргэдэд олгосон газар доорхи бусад орон зайн хэсэг;

19.4.2. агаарын тээврийн зориулалтаар ашиглагдаж байгаа агаар мандлын орон зайн хэсэг.

20 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц бий болгох

20.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг хангах төлөвлөлтийг гүйцэтгэхдээ төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан норм ба дүрэм, журамд заасныг баримтална.

20.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний саадгүй хүрч үйлчлүүлэх нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт болон барилгажилтын шийдэл, зураг төсөл, инженерийн болон нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах аливаа төсөлд зөвшөөрөл олгохыг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохицуулах

21 дүгээр зүйл. Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх

21.1. Хот байгуулалтын үйл ажиллагааг дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

21.1.1. хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүс нутгийн хөгжлийн төслийг хэрэгжүүлэхдээ эхний ээлжинд зам тээвэр, эрчим хүч, холбоожуулалтын үндсэн сүлжээг барьж байгуулах ажлыг хэрэгжүүлж зохицуулах;

21.1.2. хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ инженерийн бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр ус, цахилгаан, дулаан хангамжийн найдвартай эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, гол зам,

холбоожуулалтын сүлжээнээс эхлэн барьж байгуулах ажлыг хэрэгжүүлж зохицуулах;

21.1.3.орон сууцны хороолол, үйлдвэр, үйлчилгээний цогцолборыг зам, талбай, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, тохижилтын хамт иж бүрэн гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлж зохицуулах.

22 дугаар зүйл. Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг

22.1. Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараахь эрх, үүрэгтэй:

22.1.1. хот байгуулалтын тухай хууль тогтоомж, норм ба дүрэм, журам, стандартыг дагаж мөрдөх;

22.1.2. эдэлбэр газар эзэмших, барилга байгууламж барих, инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлыг нутгийн захиргааны байгууллага, болон эрх бүхий мэргэжлийн байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр зураг төслийн дагуу гүйцэтгэх;

22.1.3. хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд орчны бохирдлоос сэргийлэх, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангах, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх;

22.1.4. улсын экспертизийн дүгнэлт, улсын байцаагчийн шаардлагыг биелүүлэх;

22.1.5. хот байгуулалтын үйл ажиллагааны сөрөг үр дагаврыг мэдээлэх, эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

23 дугаар зүйл. Хот байгуулалтын үйл ажиллагааг хязгаарлах

23.1. Дараахь бүсэд хэрэгжүүлэх хот байгуулалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтооно:

23.1.1. түүх, соёлын дурсгалт барилга байгууламж бүхий газар нутаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд;

23.1.2. усны эх үүсвэр, усан сан бүхий газрын эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсэд;

23.1.3. ашигт малтмалын орд бүхий бүсэд;

23.1.4. байгалийн болон гэнэтийн осолд өртөх өндөр магадлалтай бүсэд;

23.1.5. экологийн онцгой болон сүйрлийн бүсэд;

23.1.6. газар дээрх болон доорхи дэд бүтэц бүхий бүсэд.

24 дүгээр зүйл. Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хориглох зүйл

24.1. Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараахь зүйлийг хориглоно.

24.1.1. хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний үндсэн шаардлага, үе шатны зорилт, эдэлбэр газрын зориулалт, инженерийн шугам сүлжээний даац, технологийн горим зөрчиж газар олгох;

24.1.2. техникийн нөхцөлийн зөвшөөрөл, бүрдэлгүй газар олгох;

24.1.3. олгосон газарт зориулалтын бус барилга байгууламж барих, хүн амын амьдрах орчны чанарт сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулах;

24.1.4. инженер-геологийн судалгаа, зураг төсөлгүй барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ барих, өргөтгөх, шинэчлэх;

24.1.5. холбогдох байгууллагаар хянагдаж баталгаажсан төв, суурин газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад тэдгээрийг зөрчих, зөвшөөрөлгүй дур мэдэн өөрчлөх;

24.1.6. инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурваст барилга байгууламж төлөвлөх, барих.

24.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах шийдвэрт хамрагдсан тухайн газар нутагт газар эзэмших, ашиглах эрх олгох болон хот байгуулалтын бусад үйл ажиллагаа явуулахыг тодорхой хугацаагаар түр зогсооно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хот байгуулалтын кадастр болон хот байгуулалтын үйл ажиллагаанд тавих хяналт, шинжилгээ

25 дугаар зүйл. Хот байгуулалтын кадастр болон хот байгуулалтын үйл ажиллагаанд тавих хяналт шинжилгээний зориулалт

25.1. Хот байгуулалтын кадастр нь хот байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх болон үл



хөдлөх эд хөрөнгийн бүртгэл хийхэд зайлшгүй шаардлагатай мэдээлэл бүхий улсын сан мөн.

25.2. Хот байгуулалтын кадастрыг хот, суурин газарт эрхэлнэ.

25.3. Газрын кадастр нь улсын хот байгуулалтын кадастрын суурь болох бөгөөд өөрийн үйл ажиллагаатай холбоотой бусад салбарын кадастрын мэдээллийг агуулна.

25.4 Улсын хот байгуулалтын кадастр улсын хэмжээнд нэгдсэн системтэй байна.

25.5. Хот байгуулалтын кадастр нь газар нутгийн хөгжлийн болон хот, суурин газрын хот байгуулалтын төлөвлөлт, барилгажилтын баримт бичиг болох бөгөөд түүнд дараахь мэдээлэл хамаарна:

25.5.1. геодези, байр зүй, зурагзүйн материал;

25.5.2. газар нутгийн экологи, инженер-геологи, газар чичирхийлэл;

25.5.3. гидрогеологийн тухай мэдээлэл;

25.5.4. хот байгуулалтын хөгжлийн болон газар, барилгажилтын тухай мэдээлэл;

25.5.5. инженерийн, зам тээврийн болон нийгмийн дэд бүтэц ба газар нутгийн тохижилтын тухай мэдээлэл.

25.6. Хот байгуулалтын кадастрын тухай мэдээлэл нь хот байгуулалт, зураг төслийн баримт бичиг боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх үндэс болно.

25.7. Хот байгуулалтын кадастрын мэдээлэл нээлттэй байна.

25.8. Энэ хуулийн 25.7-д заасан асуудалтай холбогдсон мэдээлэл буруу ташаа тарааснаас үүсэх хохирлыг уг мэдээллийг олгосон этгээд бүрэн хариуцна.

25.9. Хот байгуулалтын үйл ажиллагааны хяналт шинжилгээ нь хот байгуулалтын объектын төлөв байдал, тэдгээрийн өөрчлөлтөд ажиглалтыг идэвхтэй орчинд нэгдсэн аргачиллаар явуулах үйл ажиллагаа болно.

25.10. Хот байгуулалтын үйл ажиллагааны объектын хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг улсын хот байгуулалтын кадастрт оруулна.

26 дугаар зүйл. Хот байгуулалтын кадастр эрхлэх

26.1. Улсын хот байгуулалтын кадастрыг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан явуулна.

26.2. Хот байгуулалтын кадастр эрхлэх дүрмийг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

27 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлөх

27.1. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажил гүйцэтгэх явцад учруулсан хохирлыг тухайн үйл ажиллагааг гүйцэтгэсэн этгээд холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн төлнө.

27.2. Газарт орсон барилгыг нурааж зайлуулах, зам талбай, инженерийн шугам сүлжээ, мод зүлэг, тохижилтыг нөхөн сэргээх зардлыг захиалагч этгээд бүрэн хариуцна.

27.3. Хот байгуулалтын батлагдсан төлөвлөлтийн дагуу иргэнийг албадан нүүлгэх тохиолдолд түүний газар, бусад үл хөдлөх эд хөрөнгө болон энэ хугацаанд тухайн газарт эрхэлж байсан аж ахуйн үйл ажиллагаанаас олох байсан орлогыг нь үнэлэх асуудлыг тусгайлан хуулиар зохицуулна.

27.4. Энэ хуулийн 27.3-т заасны дагуу албадан нүүлгэх, түүнчлэн иргэний эзэмшлийн газрыг тохиролцсоны үндсэн дээр төр худалдан авах тохиолдолд нүүлгэн шилжүүлэхэд гарах тээврийн болон холбогдох бусад зардлыг иргэнд нөхөн олгоно.

28 дугаар зүйл. Хот байгуулалтын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

28.1. Хот байгуулалтын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, улсын байцаагч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

28.1.1. энэ хуулийн 11.2, 11.4, 11.6, 12.6.2, 12.6.3, 12.8-д заасныг зөрчсөн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин, аж ахуйн нэгж, байгууллагыг гучаас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төрөгөөр торгох;

28.1.2. энэ хуулийн 14, 20, 22, 23, 24 дүгээр зүйл, 19.2, 25.8-д заасныг зөрчсөн иргэнийг



хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин, аж ахуйн нэгж, байгууллагыг дөчөөс ная дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, гаргасан шийдвэрийг нь хүчингүй болгон, хохирлыг нь нөхөн төлүүлнэ.

28.2.Энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй нь тогтоогдсон бол албан тушаалтныг хөдөлмөрийн

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.1998 оны 10 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Хот байгуулалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

байгуулалтын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Хот

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Автотээврийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

худалдан авснаар тээвэрлэгчтэй хийх даатгалын гэрээг байгуулсанд тооцно."

1/9¹ дүгээр зүйл:

2/17¹ дүгээр зүйл:

"9¹ дүгээр зүйл. Тээвэрлэлтийн даатгал

"17¹ дүгээр зүйл. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл

9¹.1.Тээвэрлэлтийн даатгалыг Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон энэ хуульд нийцсэн гэрээний дагуу гүйцэтгэнэ.

17¹.1.Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ.

9¹.2.Зорчигчийн амь нас, эрүүл мэнд нь Даатгалын тухай хуулийн 6.3-т заасны дагуу заавал даатгалд хамаарна.

17¹.2.Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

9¹.3.Тээвэрлэгч нь зорчигч болон гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, ачаа тээшинд учирсан хохирлыг арилгах зорилгоор даатгалд даатгуулах үүрэгтэй.

3/19 дүгээр зүйл:

9¹.4.Энэ хуулийн 3.1.11-д заасан нийтийн тээврийн ажил, үйлчилгээг гүйцэтгэж буй тээвэрлэгч нь зорчигчийн амь нас, эрүүл мэнд, ачаа тээшинд учирсан хохирлыг арилгах зорилгоор даатгалын байгууллагатай урьдчилан гэрээ байгуулж даатгуулна.

"19 дүгээр зүйл. Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх

9¹.5.Энэ хуулийн 3.1.11-д заасан нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч нь зорчих тасалбарыг

19.1.Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан тээвэрлэлтийг гүйцэтгэхэд зохих ангиллын автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийг ажиллуулна.

19.2. Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, шалгалт авах, үнэмлэх олгох журам, үнэмлэхийн загварыг автотээврийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

19.3. Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө жолоодох эрх авсан этгээд автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу шалгалт өгч мэргэшсэн жолоочийн үнэмлэх авч болно.

4/19² дугаар зүйл:

"19² дугаар зүйл. Авто үйлчилгээний байгууллага

19².1. Авто үйлчилгээний байгууллага нь дараахь шаардлагыг хангаж ажиллана:

19².1.1. тухайн үйлчилгээний ангилал, стандартад тавигдах шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулах;

19².1.2. тухайн үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангаж буй эсэхийг хэмжилзүйн мэргэжлийн байгууллагаар жил бүр шалгуулж, баталгаажуулах.

19².2. Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журмыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

19².3. Авто үйлчилгээний байгууллага нь дараахь эрх, үүрэгтэй:

19².3.1. өөрийн ангилалд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах;

19².3.2. тухайн жилд үйлчлүүлсэн хэрэглэгчдийн талаарх судалгааг тогтоосон журмын дагуу автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх;

19².3.3. хэрэглэгчдэд үнэн бодит мэдээлэл өгөх;

19².3.4. авто үйлчилгээний ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж байх;

19².3.5. авто үйлчилгээний бүтээгдэхүүний үнэ тарифыг тогтоох;

19².3.6. эрх бүхий байгууллагаар ангиллаа тогтоолгох.

19².4. Авто үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангасан иргэн авто үйлчилгээ эрхэлж болно."

"3.1.13. "жуулчин тээвэрлэлт" гэж жуулчинд үзүүлж буй Аялал жуулчлалын тухай хуулийн 3.1.1. дэх заалтад хамаарах тээвэрлэлтийг;

3.1.14. "хүнсний технологийн тээвэрлэлт" гэж хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор түргэн муудах болон хадгалалтын тусгай горимд тухайн бүтээгдэхүүний шинж чанарыг алдагдуулахгүйгээр тээвэрлэх тээвэрлэлтийг;

3.1.15. "тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч" гэж автотээврийн хэрэгслийг жолоодох ажил гүйцэтгэж өөрт ашиг, орлого олох зорилгоор эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу сургалтын хөтөлбөрт хамрагдан мэргэжлийн үнэмлэх авсан этгээдийг;

3.1.16. "автотээврийн хэрэгслийн ашиглалт" гэж автотээврийн хэрэгслийг хадгалах, техникийн үйлчилгээ, засвар хийх, шатахуун тосолгооны болон ашиглалтын бусад материалаар хангах, техникийн хяналтыг зохион байгуулж явуулах зэрэг автотээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаанд техникийн бүрэн бүтэн байдал, найдвар ажиллагааг хангахад чиглэгдсэн техникийн ба зохион байгуулалтын арга хэмжээг;

3.1.17. "техникийн хяналтын үзлэг" гэж автотээврийн хэрэгслийн техникийн байдлыг тусгай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглан, оношлогчийн мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагад тулгуурлан, стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхэд үзлэг хийж шалгах, тодорхойлох, үнэлэх үйл ажиллагааг;

3.1.18. "авто үйлчилгээний байгууллага" гэж автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдон гарах үйлчилгээг хэрэглэгчид үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг."

6/6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, 8 дахь заалт:

"6.1.7. тээвэрлэлтийн зай, ачааны төрлөөс хамааруулж зорчигч, ачаа тээвэрлэлтийн жишиг тарифыг батлах;

6.1.8. Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтлөх ажлыг зохион байгуулах."

7/9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"9.3. Нийтийн зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг зориулалтын, стандартад нийцсэн, зүүн гар талдаа жолооны хурдтай, зорчигчийг баруун гар талруугаа буулгаж, суулгах нөхцөлийг хангасан автотээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ."

5/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13, 14, 15, 16, 17, 18 дахь заалт:



8/10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2' дахь

заалт:

"10.2.2'. тээвэрлэлтийн ажил, үйлчилгээг тухайн ангиллын тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх."

9/10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10, 11 дэх заалт:

"10.2.10.энэ хуулийн 3.1.14-т заасан тээвэрлэлтийг гүйцэтгэх бол стандартын шаардлагыг хангасан тусгай зориулалтын автотээврийн хэрэгслээр тээвэрлэх;

10.2.11.зөвхөн өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслээр улс, хот хоорондын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх."

10/17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"17.3.Энэ хуулийн 17.1-д заасан үйл ажиллагааг эрхлэн явуулах байгууллага нь автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтцэд ажиллана."

11/17 дугаар зүйлийн 5 дахь хэсэг

"17.5.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

2 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн

6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "нийтийн" гэсний өмнө "улс хоорондын зорчигч болон ачаа тээвэр," гэж, мөн заалтын "шуудан" гэсний дараа "жуулчин" гэж, мөн заалтын "эрхлэх" гэсний дараа ", тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх" гэж, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Хот хоорондын" гэсний дараа "ачаа," гэж, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын "зорчигчийг" гэсний өмнө "ачаа," гэж, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "шуудан" гэсний дараа ", жуулчин болон улс хоорондын ачаа" гэж, мөн хэсгийн "үйлчилгээ" гэсний дараа ", тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх" гэж, Дөрөвдүгээр бүлгийн гэрчгийн "хяналт," гэсний дараа "бүртгэл," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Автотээврийн тухай хуулийн

3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

"3.1.2."зорчигч" гэж автотээврийн хэрэгслээр зорчихдоо энэ хуулийн 3.1.11-д заасан нийтийн тээврийн хэрэгслээр зорчих пайз, тасалбар авсан зорчигчийг;"

2/ 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"12.2.Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.6-д заасны дагуу ахмад настан, Боловсролын тухай хуулийн 43.2.5-д заасны дагуу сурагч, оюутан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3.1-д заасан хүнд аймаг, нийслэлийн дотор нийтийн тээврийн хэрэгсэл /таксианаас бусад/-ээр зорчих нөхөн олговор олгоно."

3/ 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"15.2.Улс хоорондын болон хот хоорондын нийтийн тээвэр, шуудан, жуулчин тээвэрлэлт, улс хоорондын ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх, тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх, автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно."

4 дүгээр зүйл. Автотээврийн тухай хуулийн

23 дугаар зүйлийн 23.1.3 дахь заалтаас "15.3," гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Автотээврийн тухай хуулийн

15 дугаар зүйлийн 15.3, 15.8 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 15.15.12 дахь заалт нэмсүгэй.

"15.15.12.тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх."

2 дугаар зүйл.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.15.6 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

"15.15.6.улс хоорондын болон хот хоорондын нийтийн тээвэр, шуудан, жуулчин

тээвэрлэлт, улс хоорондын ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх.”

3 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 4 дэх хэсэг нэмсүгэй:

“4. Тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийг Автотээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэнэ.”

2 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн гарчгийн “жолооч” гэсний дараа “, мэргэшсэн жолооч” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 3 дахь заалтын “тооллого”

гэснийг, 14 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “тооллогод” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 6, 7 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, 4, 5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

АХМАД НАСТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 5.1.6¹ дэх заалтыг нэмсүгэй:

“5.1.6¹. энэ хуулийн 5.1.6-д заасан нөхөн олговор олгох журмыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, шаардагдах хөрөнгийг тухайн жилийнхээ төсөвт тусгана.”

2 дугаар зүйл. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6

дахь заалтын “үнэ төлбөргүй зорчих” гэснийг “зорчих нөхөн олговор авах,” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. (Монгол Улсын Ерөнхийлөгч 2008 оны 07 дугаар сарын 28-ны өдөр энэ хуульд бүхэлд нь хориг тавьсан)

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.5 дахь заалтын “зардлыг тухайн нутгийн захиргааны байгууллагаас тогтоосон журмын дагуу хөнгөлөх,” гэснийг “зардлын нөхөн олговрыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон журмын дагуу олгох,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн "үнэ төлбөргүй зорчино" гэснийг "зорчих зардлын нөхөн олговрыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон журмын дагуу олгоно." гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. *(Монгол Улсын Ерөнхийлөгч 2008 оны 07 дугаар сарын 28-ны өдөр энэ хуульд бүхэлд нь хориг тавьсан)*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "хэрэгслийн тоо бүртгэлийг хөтөлж, тэдгээрийг жолоодох эрхийн үнэмлэх олгоно." гэснийг "хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэх олгоно." гэж өөрчилсүгэй.

Ерөнхийлөгч 2008 оны 07 дугаар сарын 28-ны өдөр уг хуулийн энэ зүйлд хориг тавьсан)

2 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай. *(Монгол Улсын*

3 дугаар зүйл. Энэ хуулийг Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг нэмсүгэй.

1/хөрөнгө оруулагчийн нэр, хаяг, иргэний харьяалал;

1/12 дугаар зүйл:

хэмжээ;

2/хөрөнгө оруулалтын төрөл,

"12 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл олгох

3/аж ахуйн нэгжийн хэлбэр;

4/хөрөнгө оруулах үндсэн салбар, эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээ;

1. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрлийг өргөдөл, холбогдох баримт бичгийг үндэслэн гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.

5/хөрөнгө оруулах, хэрэгжүүлэх үе шат, хугацаа.

2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах тухай өргөдөлд дараахь зүйлийг тусгана:

3. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах тухай өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

1/хөрөнгө оруулагчийн тухай танилцуулга, иргэний үнэмлэх, гадаад паспорт болон хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2/гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах тухай гэрээ, дүрэм;

3/хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан эсэхийг холбогдох бүртгэх байгууллагаас шалгуулж баталгаажуулсан баримт;

4/хөрөнгө оруулагчийн төлбөрийн чадварын тухай үйлчлүүлэгч банкны тодорхойлолт /ээмшиж байгаа өмчийн тодорхойлолт/;

5/техник-эдийн засгийн үндэслэл;

6/гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн албан ёсны хаяг /хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан зориулалтын ажлын байрны түрээсийн гэрээ/;

7/Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан холбогдох зөвшөөрөл.

4.Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахыг хүссэн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хянан үзэж, өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг мэргэжлийн хяналтын байгууллагын гаргасан дараахь дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ:

1/хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх;

2/байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл;

3/стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцэж байгаа эсэх;

4/техник, технологийн түвшний үнэлгээ.

5.Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4-т заасан дүгнэлтийг Монгол Улсын Засгийн газраас баталсан журмын дагуу гаргана.

6.Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар байгуулах өргөдлийг гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандаж гаргах бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:

1/гадаадын хуулийн этгээдийн нэр, хаяг;

2/гадаадын хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар;

3/төлөөлөгчийн газар байгуулах зорилго, үйл ажиллагааны чиглэл;

4/төлөөлөгчийн газрын албан ёсны хаяг, байршил.

7.Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар байгуулах өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

1/ гадаадын хуулийн этгээдийн танилцуулга, дүрмийн хуулбар;

2/гадаадын хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар;

3/төлбөрийн чадварын тухай үйлчлүүлэгч банкны тодорхойлолт;

4/төлөөлөгчийн газрын дүрэм;

5/төлөөлөгчийн газрын хаяг /хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан зориулалтын ажлын байрны түрээсийн гэрээ/.

8.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг байгуулахыг зөвшөөрвөл гэрчилгээ олгох бөгөөд загварыг гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

9.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрээ, дүрэмд нэмэлт, өөрчлөлт орсон бол эрх бүхий байгууллагад ажлын 10 хоногийн дотор мэдэгдэх бөгөөд гэрчилгээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг ажлын 14 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

10.Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрөл олгохоос татгалзсан бол өргөдөл хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор татгалзсан үндэслэлийг заасан хариуг бичгээр өгнө.

11.Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар байгуулахыг хүссэн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хянан үзэж, өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ."

2/ 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь энэ хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан дүгнэлтийн аль нэгийг зөрчиж байгаа нь мэргэжлийн хяналтын

байгууллагын санал, дүгнэлтээр тогтоогдвол гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага уг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр буюу бүрмөсөн зогсоож болно."

3/ 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж татан буугдаж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвшөөрлийг хүчингүй болгож энэ тухай Үндэсний татварын ерөнхий газарт мэдэгдэнэ."

2 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, өөрийн хөрөнгө нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх төгрөгөөс дээш, түүний 25-аас доошгүй хувь нь гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгөөс бүрдсэн аж ахуйн нэгжийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэнэ."

2/ 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

"4/хөдөлмөр эрхлэлт, татвар, гааль, нийгмийн даатгал, гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудаас гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дараахь статистик мэдээллийг хагас, бүтэн жилээр авч нэгдсэн сан хөтлөх:

а/хөрөнгө оруулалтын хэмжээ /өөрийн хөрөнгө/;

б/татвар төлөлт;

в/нийгмийн даатгалын шимтгэл төлөлт;

г/ажлын байрны тоо;

д/гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл;

е/экспорт, импортын хэмжээ, нэр, төрөл."

гарчгийн "гадаадын хуулийн этгээдийн салбарын үйл ажиллагаа" гэснийг "гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа" гэж, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалт, 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн гарчиг, 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн "нэгж" гэснийг "нэгжийн" гэж, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн гарчиг, 17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "нэгж" гэснийг "нэгжийг" гэж, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн гарчиг, 21 дүгээр зүйлийн 1, 3, 5 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн "нэгж" гэснийг "нэгжид" гэж, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "2.0 сая ам. доллар" гэснийг "20 сая америк доллар" гэж, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "2.0 -10.0 сая ам доллар" гэснийг "20 сая америк доллар" гэж, мөн хэсгийн "10.0 сая ам. доллар" гэснийг "50 сая америк доллар" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 1, 4, 5 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 23 дугаар зүйл, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "гадаадын хуулийн этгээдийн салбар" гэснийг, 6 дугаар зүйлийн 1 дэх заалтын "салбар нэгжээ нээн ажиллуулах" гэснийг, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын "гадаадын хуулийн этгээдийн салбар нээн ажиллуулах" гэснийг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтын "салбар нэгж," гэснийг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалт, 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн гарчиг, 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн "гадаадын хуулийн этгээдийн салбарын" гэснийг, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн гарчиг, 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "гадаадын хуулийн этгээдийн салбарыг" гэснийг, 15 дугаар зүйлийн гарчиг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "гадаадын хуулийн этгээдийн салбар," гэснийг, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн гарчиг, 21 дүгээр зүйлийн 1, 3, 5 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн "гадаадын хуулийн этгээдийн салбар" гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн Гуравдугаар бүлгийн

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Компанийн тухай хуулийн 32.1 дэх хэсэгт "Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ заалт хамаарахгүй." гэсэн 3 дахь өгүүлбэр нэмсүгэй.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16.1.5 дахь заалтыг "16.1.5. Гадаадын иргэн, гадаадын хуулийн этгээд үүсгэн байгуулагчаар оролцож байгаа бол гадаад паспортын хуулбар, хуулийн этгээдийн тухайн улс дахь улсын бүртгэлийн бичилтийн хуулбар, гадаадын хөрөнгө оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн

гэрчилгээний хуулбар;" гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 164

Улаанбаатар хот

Нэрэмжит болгох тухай

Холбогдох байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Хүүхдийн ордныг Монгол Улсын Төрийн шагналт, Ардын жүжигчин Цэрэндүлэмын Сэвжидийн;

2. Төв аймгийн Баянцогт сумын бүрэн дунд сургуулийг Монгол Улсын гавьяат жүжигчин Лувсанбалдангийн Лувсангийн;

3. Говь-Алтай аймгийн Алтай сумын дунд сургуулийг Монгол Улсын Төрийн шагналт Оросын Батмөнхийн нэрэмжит тус тус болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД Н.БОЛОРМАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 167

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг зохион байгуулж, дор дурдсан арга хэмжээ авч ажиллан дүнг нэгтгэн

2008 оны Ш улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд даалгасугай.

а) төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон 2008 оны П улиралд багтаан явуулах;

б) улсын төсвийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр бий болсон оюуны өмч, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын газар эзэмших эрх, ашигт малтмалын лиценз зэрэг эдийн бус баялгийг үзлэг, тооллогод хамруулан бүртгэлд тусгах;

в) төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогод хийхэд мөрдөх аргачлал, маягтыг бүртгэлийн нэгдсэн тогтолцоотой уялдуулан боловсруулж мөрдүүлэх арга хэмжээ авах;

г) гадаад улсад байгаа Монгол Улсын өмчийг тооллогод хамруулан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаархи санал боловсруулан Засгийн газарт танилцуулах.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнг төсвийн ерөнхийлөн захиралч болон Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд бүрэн тусгуулан хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд даалгасугай.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулахад шаардагдах 76284,2 (далан зургаан сая хоёр зуун наян дөрвөн мянга хоёр зуун) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

4. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг Төрийн өмчийн хорооны мэргэжил, арга зүйн удирдлагын дагуу орон нутагтаа зохион байгуулж дүнг 2008 оны П улиралд багтаан Төрийн өмчийн хороонд ирүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **Н.ЭНХБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 168

Улаанбаатар
хот

Зээл олгох тухай

Тариалангийн тухай хуулийн 4.1.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Атрын гурав дахь аян" тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг Төв, Сэлэнгэ, Булган аймагт хэрэгжүүлэхэд нэмж шаардагдах тус бүр 2 (хоёр) тэрбум төгрөгийг төсвийн зээл хэлбэрээр олгохыг Сангийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. "Атрын гурав дахь аян" тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дээрх 3 аймагт нэмж олгосон 6 (зургаан) тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Төв, Сэлэнгэ, Булган аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

САНГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 170

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Улсын Их Хурлын 1998 оны 5 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. «Улсын хилээр нэвтрүүлэх байлдааны зориулалттай хэрэгсэл, техникт экспорт, импортын лиценз олгох журам»-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Улсын хилээр нэвтрүүлэх байлдааны зориулалттай хэрэгсэл, техникт экспорт, импортын

лиценз олгох асуудлыг хянан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Ж.Батхуягт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД** **Ж.БАТХУЯГ**

Засгийн газрын 2008 оны 170 дугаар
тогтоолын хавсралт

УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ БАЙЛДААНЫ ЗОРИУЛАЛТТАЙ ХЭРЭГСЭЛ, ТЕХНИК ЭКСПОРТ, ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. "Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай" Улсын Их Хурлын 1998 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан "Зэвсэг, байлдааны хэрэгсэл, техник, тэдгээрийн эд анги, тоног хэрэгсэл"-д (цаашид байлдааны хэрэгсэл гэх) экспорт, импортын лиценз (цаашид лиценз гэх) олгоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Байлдааны хэрэгсэл, техник, тоног хэрэгсэл гэдэгт гарал үүслийн хувьд цэргийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн, зэвсэгт хүчин, бусад цэрэг, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор ашиглаж байгаа зэвсэг, техник, тэдгээрийн эд анги, сум галт хэрэгсэл, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ойлгоно.

1.3. Улсын хилээр нэвтрүүлэх байлдааны хэрэгсэлд экспорт, импортын лицензийг батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Зэвсэгт хүчний Жанжин штаб, Тагнуулын ерөнхий газрын тодорхойлолтыг үндэслэн олгоно.

1.4. Байлдааны зориулалттай хэрэгслийн экспорт, импортын үйл ажиллагаа нь төрийн нууцад хамаарч байгаа бол Төрийн нууцын тухай болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөн нууцыг хамгаалах арга хэмжээ авна.

1.5. Батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь лиценз олгох эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсгийн баталгааг Улсын гаалийн ерөнхий газарт хүргүүлнэ.

Хоёр. Лиценз авах өргөдөл гаргах, хянан шийдвэрлэх журам

2.1. Байлдааны хэрэгслийг экспортлох, импортлох лиценз хүссэн өргөдлийг лиценз хүсэгч Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолоор баталсан "Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам"-ын 1 дүгээр хавсралтад заасан "MNS5022.2001" стандартын "E" маягтаар гаргана. Өргөдөлд дурдсан мэдээллийн үнэн зөвийн хариуцлагыг өргөдөл гаргагч хүлээнэ.

2.2. Лиценз олгох өргөдөлд дор дурдсан баримт бичгийг хавсаргана:

2.2.1. өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.2.2. байлдааны хэрэгслийг экспортлох, импортлохтой холбогдолтой гэрээ (контракт), төрийн байгууллагын шийдвэрийн хуулбар.

2.3. Лиценз олгох гэж байгаа байлдааны хэрэгслийн онцлогоос шалтгаалан бусад шаардлагатай тодорхойлолт, дүгнэлтийг лиценз хүсэгчээс гаргуулж авна.

2.4. Батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага өргөдөл болон хавсаргасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

2.5. Батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар шалгуулах, магадлан шинжилгээ хийлгүүлэх эрхтэй. Энэ тохиолдолд лиценз хүссэн өргөдлийг шийдвэрлэх хугацааг ажлын 30 хоногоор сунгаж болно.

2.6. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол лицензийг Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолоор баталсан "Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам"-ын 2 дугаар хавсралтад заасан "MNS5022.2001" стандартын "D" маягтаар олгоно.

2.7. Лицензийг 1 жил хүртэл хугацаагаар олгоно. Лицензийг нэг эх хувь, хоёр хуулбар хувь үйлдэнэ. Лицензид нэр заасан байлдааны хэрэгслийн хадгалалт, тээвэрлэлт, хамгаалалт, чанар стандартын шаардлага, нөхцөлийг хангасан байх үүргийг лиценз эзэмшигч өөрөө хариуцна.

2.8. Лицензийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж болохгүй.

Гурав. Лицензийн хугацааг сунгах, лицензид нэмэлт, өөрчлөлт оруулах, лицензийг хүчингүй болгох

3.1. Экспорт, импортын гэрээний үүрэг биелүүлэх хугацаа, шаардлагатай уялдуулан

лицензийг 1 жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно. Батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага лиценз сунгах болон лицензид заасан байлдааны хэрэгслийн нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, нэвтрүүлэх боомтын нэрийг өөрчлөх, тодотгох өргөдлийг 3 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Лиценз сунгах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах өргөдлийг лиценз хүчинтэй байх хугацаанд гаргана.

3.2. Батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараахь тохиолдолд лицензийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгоно:

3.2.1. лиценз эзэмшигч хүсэлт гаргасан;

3.2.2. лиценз эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан;

3.2.3. лиценз авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;

3.2.4. олгосон лицензийг засварласан;

3.2.5. гаалийн бүрдүүлэлт хийхэд хуурамч мэдээлэл өгсөн.

3.3. Батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага лицензийг хүчингүй болгосон тухайгаа шийдвэр гаргаснаас хойш 3 хоногийн дотор лиценз эзэмшигч болон гаалийн байгууллагад мэдэгдэнэ.

Дөрөв. Тайлан, мэдээ гаргах

4.1. Батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага олгосон лицензийн талаархи мэдээллийг Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолоор баталсан "Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам"-ын 3, 4 дүгээр хэвсрэлтэд заасан маягтын дагуу гаргана.

4.2. Батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага лиценз олгох талаар дагаж мөрдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомж, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, олгосон лицензийн тухай нэгдсэн судалгааг гаргаж, холбогдох байгууллагад зохих журмын дагуу мэдээлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 21.4, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Улсын төсөв болон даатгалын сангийн санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл

мэндийн байгууллагыг сонгох журмыг хавсралтын ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

Б.БАТСЭРЭЭДЭНЭ

Засгийн газрын 2008 оны 172 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСӨВ БОЛОН ДААТГАЛЫН САНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ СОНГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуулийн 28¹ зүйл, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.1 дэх заалтад тус тус заасан үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон

шалгаруулах үйл ажиллагаа нь Эрүүл мэндийн тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд явагдана.

1.3. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулахдаа Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.2 дахь заалтыг баримтална.

1.4. Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах ажлын зохион байгуулах үйл ажиллагаанд нь хяналт тавих үүргийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга хүлээнэ.

1.5. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга энэхүү журмын 1.4-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслах мэргэжил арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүргийг улсын хэмжээнд эрүүл мэндийн сайдын эрх олгосон байгууллага, аймаг, нийслэлд Эрүүл мэндийн газар гүйцэтгэнэ.

1.6. Сонгон шалгаруулалтад хамрагдах тусламж үйлчилгээний төрөл, хамрах хүрээ, сонгон шалгаруулалт явуулах хугацаа, эрүүл мэндийн байгууллагад тавих шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалыг энэхүү журмын 1.5-д заасан байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

Хоёр. Сонгон шалгаруулах комисс байгуулах

2.1. Улс, бүсийн хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, аймаг, нийслэлийн хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагыг аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон комисс (цаашид "комисс" гэх) сонгон шалгаруулна.

2.2. Комисс нь дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна. Комиссын бүрэлдэхүүнд эрүүл мэнд, санхүү, нийгмийн даатгал, мэргэжлийн хяналт болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, иргэний төлөөлөл орсон байна.

2.3. Сонгон шалгаруулалтыг явуулах бүрт комиссыг шинээр байгуулна.

2.4. Комисс нь сонгон шалгаруулалттай холбогдсон аливаа асуудлыг хурлаараа хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.5. Комиссын үйл ажиллагаанд энэхүү журмын 1.5-д заасан байгууллага шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

Гурав. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

3.1. Энэхүү журмын 1.5-д заасан байгууллага нь ирүүлсэн материалыг зохих журмын

дагуу нэг бүрчлэн бүртгэн хүлээн авч битүүмжилсэн хэвээр сонгон шалгаруулах комисст хүлээлгэн өгч, акт үйлдэнэ.

3.2. Комисс нь сонгон шалгаруулалтыг дараахь дэс дарааллаар явуулна:

3.2.1. сонгон шалгаруулалтад оролцогчдын төлөөллийг байлцуулан ирүүлсэн санал бүрийн битүүмжлэлийг шалган задалж, сонгон шалгаруулалтын материал бүрэн эсэх, зохих журмын дагуу үйлдэгдсэн эсэхийг шалгаж хүчинтэй саналуудыг бүртгэн авах;

3.2.2. ирүүлсэн санал бүртэй гишүүд танилцаж, үнэлгээ өгөх;

3.2.3. сонгон шалгаруулалтын дүнг хурлаараа хэлэлцэж, тэнцсэн эрүүл мэндийн байгууллагыг тодорхойлох;

3.2.4. сонгон шалгаруулалтын дүнг мэдээлэх;

3.2.5. сонгон шалгаруулалт явуулсан тухай ажлын тайланг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

3.2.6. сонгон шалгаруулалттай холбогдсон санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх.

3.3. Сонгон шалгаруулалтын явц, дүнг комиссын хурлаар хэлэлцэн зөвлөмж гаргана. Комиссын зөвлөмжид дарга, гишүүд гарын үсэг зурж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

3.4. Комиссын зөвлөмжийг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэр гаргана.

Дөрөв. Гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэх

4.1. Комиссын зөвлөмжийг үндэслэн Эрүүл мэндийн тухай хуулийн 28¹ зүйлд заасан тусламж, үйлчилгээг үзүүлэхээр сонгосон эрүүл мэндийн байгууллагатай эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга "Төсвийн хөрөнгөөр тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулна.

4.2. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.1-д заасан тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагатай "Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх



тусламж, үйлчилгээний гурвалсан гэрээ"-г эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын дарга тус тус байгуулна.

4.3. Энэхүү журмын 4.1 ба 4.2-т заасан гэрээний хэрэгжилтийн явцыг үнэлэх, гэрээ дүгнэх ажлыг энэхүү журмын 1.5-д заасан байгууллага гүйцэтгэж, дүнг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулна.

4.4. Гэрээгээр тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн явцын үнэлгээ болон мэргэжлийн хяналтын байгууллагын шалгалтаар эерчил дутагдал илэрсэн, гэрээний хэрэгжилтийг хангалтгүй гэж үнэлсэн бол гэрээг цуцалж энэхүү журмын дагуу сонгон шалгаруулалтыг дахин явуулна.

Тав. Бусад зүйл

5.1. Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон

шалгаруулахад улс төрийн хүчин, төрийн өндөр албан тушаалтан, төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс комиссын үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхийг хориглоно.

5.2. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмыг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

5.3. Сонгон шалгаруулалтад тэнцсэн, гэрээгээр тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллага гэрээнд тусгагдаагүй нэмэлт тусламж, үйлчилгээ зайлшгүй шаардлагаар гүйцэтгэх тохиолдолд тухайн үйлчилгээнд нэмэлт гэрээ байгуулна.

5.4. Сонгон шалгаруулахтай холбогдсон асуудлаар гарсан маргааныг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.

5.5. Сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн байгууллага нь улсын төсөв болон даатгалын сангаас санхүүжиж байгаа тусламж, үйлчилгээнд үйлчлүүлэгчээс нэмэлт төлбөр авахыг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

ОРОН СУУЦНЫ БОЛОН ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ ХУУЛИУДЫН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Орон сууцны тухай хууль, Орон сууц хувьчлах тухай хуулийн зарим зүйл заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн Хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон **Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:**

хамаарах, тухайн хөрөнгөөр засвар, үйлчилгээ, тохижилт нь хийгдэх, сууц өмчлөгчдийн тухайн холбооны эзэмшил, ашиглалтад байгаа, оршин суугч болон сууц өмчлөгч нарт зориулагдсан ногоон байгууламж, зүлэг, хүүхдийн тоглоомын талбай, сүүдрэвч, явган хүний зам, автомашины зогсоол, тэдгээртэй адилтгах байгууламж бүхий нийтийн эдлэлбэрийн газрыг хамааруулж ойлгоно.

Сууц өмчлөгчдийн холбоо Газрын тухай хуулийн 44¹ дүгээр зүйлд зааснаар тухайн шатны Засаг даргын шийдвэрээр орчны газрыг ашиглах гэрээг эрх бүхий этгээдтэй байгуулсан байна.

1.2. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан "эрх бүхий мэргэжлийн байгууллага буюу хувь хүн" гэж дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээ, тохижилтын ажлын онцлогоос шалтгаалан, тухайн ажил, үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх тусгай зөвшөөрөл авсан, эсхүл мэргэжлийн хувьд эрхлэн гүйцэтгэдэг байгууллага, иргэнийг хэлнэ.

Нэг. Орон сууцны тухай хуулийн зарим заалтыг дараах байдлаар тайлбарласугай:

1.1. Орон сууцны тухай хуулийн /цаашид хуулийн гэх/ 14 дүгээр зүйлийн 14.1.-д заасан "дэвсгэр болон орчны газар, орчны зам, талбай" гэдэгт энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.-т зааснаар орон сууцны дэд бүтэц болох, Иргэний хуулийн 142 дугаар зүйлийн 142.2., Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6., 15 дугаар зүйлийн 15.1.-д тодорхойлсноор сууц өмчлөгчдийн дундын өмчлөлд

1.3. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан “**эрх бүхий байгууллага**” гэдэгт тухайн орон сууцны инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг засварлах ажлыг хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр эрхлэн хариуцах мэргэжлийн байгууллагыг хамааруулна.

1.4. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т зааснаар сууц өмчлөгчдийн холбоо нь “**ээгүй байсан оршин суугчийн эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ**”-г тухайн эд хөрөнгийг байгаа байранд нь хамгаалах, байршлыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай тохиолдолд өөр газарт зөөн байрлуулах, хадгалах, цоож, хаалгыг эвдлэх, орон байранд нэвтрэн орох зэргээр хэрэгжүүлэхдээ энэ зүйлд зааснаар оршин суугчдын төлөөлөгчийг байлцуулах, акт үйлдэх шаардлагыг биелүүлэхийн зэрэгцээ бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх үүргийн харилцааг зохицуулсан Иргэний хуулийн 491 дүгээр зүйлийн шаардлагыг хангасан байвал зохино.

1.5. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан “**сууц өмчлөгч нь бусад оршин суугчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр ... үйлдвэрлэл, үйлчилгээ сууцандаа эрхэлж болно**” гэдгийг энэ хууль болон бусад хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээг орон сууцандаа эрхэлж болно гэж ойлгоно.

Уг үйлдвэрлэл, үйлчилгээг өмчлөгч дангаараа эсхүл гэр бүлийн гишүүд болон бусадтай хамтран, эсхүл хуулийн этгээд байгуулах замаар тус тус эрхлэн хэрэгжүүлэх боломжтойн зэрэгцээ орон сууцны эзэмших, ашиглах эрхийг гэрээгээр бусдад шилжүүлсэн тохиолдолд гэрээний дагуу орон сууцыг хууль ёсоор эзэмшиж, ашиглаж байгаа этгээд өмчлөгчийн адил эдгээр үйлдвэрлэл, үйлчилгээг явуулах эрхтэй байна.

1.6. Мөн зүйлийн 16.4-т заасан “**төрийн эрх бүхий байгууллага**” гэдэгт энэ зүйлийн 16.3-т заасан хяналт шалгалтын байгууллагыг ойлгоно.

Энэ зүйл, хэсэгт заасан “**сууц өмчлөгчийн эрхийг шууд буюу шууд бус хэлбэрээр хязгаарлах**” гэж дээр дурдсан байгууллага, тэдгээрийн албан тушаалтан өөрийн шийдвэр, үйл ажиллагаагаар орон сууц өмчлөгчийн орон сууцаа эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг эдлэх боломжгүй болгохыг хэлнэ.

1.7. Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасан “**төв суурин газарт зөвшөөрөлгүйгээр орон сууц барьсан**” гэдэгт өмчлөх, эзэмших,

ашиглах эрхгүй газарт, эсхүл хууль тогтоомжид заасан тусгай зөвшөөрөлгүйгээр орон сууц барих зэрэг тохиолдлуудыг хамааруулна.

1.8. Мөн зүйлийн 18.2-т заасан “**хариуцлага хүлээлгэсэн эсэхийг харгалзахгүйгээр бусдад учруулсан хохирлыг хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлэх буюу арилгуулна**” гэдгийг орон сууцны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэсэн явдал нь түүний хууль бус үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй гэж ойлгоно.

Гэм буруутай этгээд хохирлыг Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1-д зааснаар гэм хор учруулахаас өмнөх байдлыг сэргээх хэлбэрээр **арилгах**, ийнхүү сэргээх боломжгүй бол мөнгөн хэлбэрээр **нөхөн төлөх** үүрэг тус тус хүлээнэ.

Хоёр. Орон сууц хувьчлах тухай хуулийн зарим заалтыг дор дурдсанаар тайлбарласугай.

2.1. Орон сууц хувьчлах тухай хуулийн /цаашид хууль гэх/ 6 дугаар зүйлийн 3-т заасан “**Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа орон сууц**” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газрын эзэмшил, ашиглалтад байгаа хувьчлагдах орон сууцыг хэлнэ.

2.2. Мөн зүйл, хэсэгт заасан “**Хуулийн этгээдийн санал**” гэдэгт төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад байгаа орон сууцыг хувьчлах асуудлаар шийдвэр гаргах эрх бүхий этгээдээс Засгийн газарт хандаж гаргасан хүчин төгөлдөр баримт бичгийг ойлгоно.

2.3. Мөн зүйлийн 4-т заасан “**Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд байгаа орон сууц**” гэдэгт төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад байгаа орон сууцыг хамааруулах бөгөөд түүнийг хувьчлах эсэх асуудлыг бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.

2.4. Хуулийн 7 дугаар зүйлийн 2-т заасан “**гэр бүл тус бүр өөрийн эзэмшиж байгаа өрөө болон тухайн сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгөөс оорт оногдох хэсгийг хувьчлан авах эрхтэй**”

гэдгийг хувьчлагдах орон сууцны тухайн гэр бүлийн хууль ёсоор эзэмших эрхийн бичгийн үндсэн дээр эзэмшиж, ашиглаж байгаа хэсгийг хувийн өмчлөлд шилжүүлэх эрхтэй гэж ойлгоно.

Харин энэ зүйл, хэсэгт заасан тухайн сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгөөс өөрт ногдох хэсгийг зөвхөн дундаа хамтран өмчлөх хэлбэрээр өмчлөлдөө авч болно.

2.5. Хуулийн 23 дугаар зүйлийн 4-т заасан "Төрийн өмчийн хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно" гэдгийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11.-д заасан

харъяаллын дагуу Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргана гэж ойлгоно.

2.6. Хуулийн 23 дугаар зүйлийн 5-д заасан "орон сууц эзэмших эрхтэй холбогдон үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ" гэж хувьчлагдах орон сууцны эзэмшигч хэн болох талаарх маргааныг ерөнхий харъяаллын шүүх иргэний журмаар хянан шийдвэрлэхийг хэлнэ.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

А.ДОРЖГОТОВ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг удирдлага болгон **Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:**

1. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн /цаашид хууль гэх/ 5 дугаар зүйлийн 5.1.-д **"Сууц өмчлөгчдийн холбоо /цаашид "холбоо" гэх/-ны эрх зүйн байдал нь Иргэний хуулийн 143 дугаар зүйл болон энэ хуулиар тодорхойлогдоно"** гэж зааснаар Сууц өмчлөгчдийн холбоо нь хуулийн этгээдийн эрхгүй байгууллага бөгөөд Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.-д зааснаар иргэний эрх зүйн харилцааны оролцогч байна.

Иргэний эрх зүйн харилцааны оролцогчийн хувьд гэрээний болон гэрээний бус үүргийн харилцаанаас үүссэн маргаанд, мөн Иргэний хуулийн 149 дүгээр зүйлд зааснаар сууц өмчлөгч хуульд заасан үүргээ биелүүлэхгүй, зөрчил гаргасан тохиолдолд Сууц өмчлөгчдийн холбоо өөрийн төлөөлөгчөөр дамжуулан шүүхэд нэхэмжлэл гаргах, хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор оролцох эрхтэй.

2. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.-д зааснаар сууц өмчлөгчдийн холбоо нь **"засвар, үйлчилгээ хийлгэх мэргэжлийн байгууллагаа чөлөөтэй сонгох эрх"**-ийг дундын өмчлөлийн эд хөрөнгө, шугам сүлжээний засвар, үйлчилгээний ажлын онцлогоос шалтгаалан, тухайн ажил, үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх тусгай зөвшөөрөл авсан, эсхүл мэргэжлийн хувьд эрхлэн гүйцэтгэдэг байгууллагатай гэрээ байгуулах замаар, энэ ажлыг хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тодорхой байгууллагад эрхлэн хариуцуулаагүй тохиолдолд хэрэгжүүлнэ.

3. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.-т заасан орон сууц өмчлөгчийн хүлээх үүргийг доорх байдлаар тайлбарласугай:

3.1. Энэ зүйлийн 13.2.6.-д зааснаар сууц өмчлөгч нь **"сууцаа бусдад эзэмшүүлж, ашиглуулж байгаа бол эзэмшигч, ашиглагчийн гүйцэтгээгүй үүргийг"** Иргэний хуулийн 148 дугаар зүйлийн 148.2.6.-д зааснаар хамтран хариуцах хэлбэрээр гүйцэтгэнэ. Сууц өмчлөгч энэ үүргийг дангаар гүйцэтгэсэн тохиолдолд Иргэний хуулийн 242 дугаар зүйлд зааснаар хамтран үүрэг гүйцэтгэгчээс өөрт учирсан хохирлыг шаардах эрхтэй.

3.2. Сууц өмчлөгч нь энэ зүйлийн 13.2.7.-д зааснаар **"сууцныхаа зориулалт, төлөвлөлт, үндсэн бүтээц, хийц, инженерийн шугам сүлжээг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөхгүй байх"** гэдэг нь Орон сууцны тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмаас гадуур орон сууцны зориулалт, төлөвлөлт, барилгын үндсэн бүтээц, хийц болон инженерийн шугам сүлжээг орон сууцны барилгын анхны зураг төслөөс өөрчлөхгүй байхыг хэлнэ.

3.3. Мөн зүйлийн 13.2.8.-д зааснаар орон сууц өмчлөгч **"сууц өмчлөх эрхээ бусдад шилжүүлэхдээ холбоонд мэдэгдэх үүрэг"**-ээ хэрэгжүүлснээр холбооноос зөвшөөрөл авах биш харин түүнд мэдээлэл өгөх үүргийг биелүүлэх тул уг үүрэг нь энэ зүйлийн 13 дугаар зүйлийн 13.1.2.-т заасан дангаар өмчлөх сууцаа холбооноос зөвшөөрөл авахгүйгээр захиран зарцуулах түүний эрхийг хязгаарлахгүй.

3.4. Мөн зүйлийн 13.3.-т заасан **"сууц худалдан авагч нь сууцыг өөрийн өмчлөлдөө шилжүүлэхээс өмнө уг сууцтай холбоотой биелэгдээгүй үүрэг байгаа эсэхийг ... холбогдох байгууллагуудаас магадлах"** гэдэгт Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1.-д заасан халаалт, халуун, цэвэр, бохир ус, ариутгал, хог, цахилгаан, холбоо зэрэг ашиглалтын төлбөр, мөн дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар, үйлчилгээтэй холбогдсон зардлыг эрх бүхий байгууллага болон сууц өмчлөгчдийн холбоонд төлсөн эсэхийг эдгээр байгууллага, эсхүл уг төлбөрийг гүйцэтгэдэг банк, тооцооны байгууллагаас лавлахыг ойлгоно.

3.5. Мөн зүйл, заалтын **"уг үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаварыг өөрөө бүрэн хариуцна"** гэж орон сууцны шинэ өмчлөгч уг орон сууцтай холбогдсон аливаа үүргийг өөрийн зардал, хөрөнгөөр гүйцэтгэхийг хэлнэ.

Орон сууцыг худалдан авсан этгээд өөрт учирсан хохирлыг худалдах-худалдан авах гэрээний харилцааг зохицуулсан Иргэний хуулийн холбогдох зүйл, заалтын дагуу худалдагчаас шаардах эрхтэй.

4. Хуулийн 15 дугаар зүйлд заасан орон сууц өмчлөгчдийн дундын эд хөрөнгийн талаарх зарим зохицуулалтыг доорх байдлаар тайлбарласугай:

4.1. Уг зүйлийн 15.1.1-д заасан **"тэдгээртэй адилтгах байгууламж"** гэдэгт Орон сууцны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан орон сууцны дэд бүтцэд хамаарах, энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6.-д заасан байгууламжийг хамааруулан ойлгоно.

4.2. Мөн зүйлийн 15.5.-д заасан **"дундын өмчлөлийн эд хөрөнгийг гэрээний үндсэн дээр тодорхой нэг этгээдийн эзэмшил, ашиглалтад шилжүүлж болно"** гэснийг сууц өмчлөгчдийн холбоо зөвхөн холбооны дүрэмд заасан тохиолдолд хэрэгжүүлэх бөгөөд уг эрх нь Иргэний хуулийн 147 дугаар зүйл болон энэ зүйлийн 15.1.-д нэрлэгдсэн боловч эрх бүхий этгээдийн шийдвэрээр бусдын эзэмшил, өмчлөлд шилжсэн, тухайн орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгөд ордоггүй эд хөрөнгөд хамаарахгүй.

4.3. Мөн зүйлийн 15.8.-д зааснаар **"орчны газрыг холбоо гэрээний үндсэн дээр ашиглана"** гэснийг энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4., Газрын тухай хуулийн 44¹ дүгээр зүйлд заасан журмын дагуу тухайн шатны Засаг даргын шийдвэрээр эрх бүхий этгээдтэй байгуулсан газар ашиглалтын гэрээгээр ашиглахыг ойлгоно.

5. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.-д **"дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, хамгаалалт, үйлчилгээний зардлыг хуваарилахдаа Иргэний хуулийн 147 дугаар зүйлийг мөрдлөг болгоно"** гэж зааснаар энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1.-д заасан дундын өмчлөлийн эд хөрөнгийн эвдрэл, гэмтлийн засварын, мөн хэвийн байдал, ажиллагааг хангах хамгаалалт, үйлчилгээний зардлыг сууц өмчлөгч бүрт хуваарилах аргачлалыг Иргэний хуулийн 147 дугаар зүйлд заасан зохицуулалтаар тогтооно.

Харин Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.4.-т дангаар өмчлөх талбайн хэмжээг тодорхойлох арга нь зөвхөн дээрх зардлыг сууц өмчлөгч нарт хуваарилах асуудалд хамааралтай тул үүнийг ажил гүйцэтгэх болон худалдах-худалдан авах гэрээний зүйл болох орон сууцны талбайн хэмжээг тодорхойлоход хэрэглэхгүй.

6. Хуулийн 20 дугаар зүйлд зааснаар сууц өмчлөгчдийн холбоог татан буулгахад Иргэний хуулийн 32 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ С.БАТДЭЛГЭР

ТАНХИМЫН ТЭРГҮҮН Ц.АМАРСАЙХАН

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 22 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн талаар заасан Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хуулийн /цаашид хуулийн гэх/ 22 дугаар бүлэгт заасан **"Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис"** гэдгийг "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д зааснаар ойлгоно.

2. Хуулийн 192 дугаар зүйлийн зарим заалтыг дор дурдсанаар тайлбарласуяй.

2.1 **"Бэлтгэсэн"** гэж байгальд ургадаг мансууруулах бодис бүхий ургамлыг түүж цуглуулсан, цэвэршүүлснээс гадна мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг дахин боловсруулж, хувирган өөрчилсөн, тун орцыг нэмэгдүүлсэн буюу багасгасан, бэлэн бүтээгдэхүүн, түүхий эдийн хэлбэрээр гаргаж авсан зэргийг хэлнэ.

2.2 **"Олж авсан"** гэдэгт мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хуулийн 194 дүгээр зүйлийн 194.1-д зааснаас бусад аргаар өөрийн эзэмшлийг болгоход чиглэгдсэн аливаа идэвхтэй үйлдэл хийхийг ойлгоно.

2.3 **"Хадгалсан"** гэж мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг биедээ авч явах, эсхүл орон байр, агуулах сав, түүнчлэн тусгайлан бэлтгэсэн нуувч зэрэг газарт байлгахыг хэлнэ.

2.4 **"Тээвэрлэсэн"** гэдэгт мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил буюу далд хэлбэрээр зөөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлэхийг ойлгоно.

2.5 **"Илгээсэн"** гэдэгт мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг шуудан буюу тээшийн илгээмжийн журмаар эсхүл бусад аргаар нэг газраас нөгөөд шилжүүлэх, уг ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлэхийг ойлгоно.

2.6 **"Борлуулсан"** гэж мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг худалдах, арилжих, солилцох, бэлэглэх эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцох (өрөнд өгөх г.м) зэргээр аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хэлнэ.

Хэрэв бусдын мөнгө, эд хөрөнгийг хууль бусаар авах зорилгоор мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын оронд өөр зүйл борлуулсан бол уг үйлдлийг бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэргээр зүйлчилнэ.

Энэ тохиолдолд худалдан авагчийн үйлдлийг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар олж авахыг завдсанаар зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

3. Хуулийн 194 дүгээр зүйлийн 194.1-д заасан **"...завших..."** гэдэгт санамсаргүй олдсон, түүнчлэн хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар, үнэ төлбөргүй, өөрийн мэдэлд шилжүүлэн авахыг хэлнэ.

4. Мөн зүйлийн 194.2.2-т заасан **"мэргэжлийн болон албан тушаалын байдлаа ашиглах"** гэдэгт мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг бэлтгэх, үйлдвэрлэх, боловсруулах, хуваарилах, худалдах, хадгалах, бүртгэх, тээвэрлэх, устгах, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрүүлэх, мөн дээрх эм, бэлдмэл, бодисыг эмчилгээ, шинжилгээ, сургалт судалгааны зорилгоор ашиглах, хэрэглэх, түүнчлэн эдгээр ажиллагаанд хяналт тавих чиглэлээр хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу өөрт нь олгогдсон албаны хийгээд бусад бүрэн эрхийг санаатайгаар харш ашигласан явдлыг хамааруулж үзнэ.